

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**



**/Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг
сайжруулах шаардлагатай байна./**

Улиастай 2018 он

АГУУЛГА

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй	1
Бүлэг 1. Ахлах нягтлан бодогч нь ажлын дадлага туршлагагүй, төсвийн шууд захирагчаас санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.	2
1.1 Үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төлөвлөгөөнөөс 36,5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна	3
1.2 Үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийг зориулалтын бус, бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан байна	4
1.3 Нэмэлт санхүүжилтийг холбогдох зардлуудад зарцуулсан байна.	8
1.4 Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна	9
1.5 Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна	9
БҮЛЭГ 2. Хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд тавих хяналт хангалтгүй байна	10
2.1 Одоо ашиглаж байгаа хөрөнгө нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна	10
2.2 Хандив тусламж болон хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна	10
Дүгнэлт	11
Зөвлөмж	14

Аудитыг гүйцэтгэсэн:

Аудитор Б.Жалбаа

Утас: 8933-0330

Аудитор Г.Чулуунбаатар

Утас: 9908-4581

Аудитыг хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Л.Уламбаяр

Утас: 9905-8189

Аудитын менежер:

Г.Хашцэцэг

Утас: 9901-9467

Хаяг: Улиастай сум, Жинст

баг, Нутгийн удирдлагын

ордон 309, 310 тоот

АУДИТЫН ЗОРИЛТ ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ:

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны 05 сарын 21-ний өдрийн А/125 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний Аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэвт нэмэлт өөрчлөлт орсон төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- 2017 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт

3. Аудитын хамрах хүрээ

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагааг хамрууллаа.

4. Үндсэн мэдээлэл

Онцгой байдлын газар нь газар, урьдчилан сэргийлэх тасаг, эрэн хайх аврах бүлэг, улсын нөөцийн салбар, Тосонцэнгэл сум дахь онцгой байдлын хэлтэс, Тосонцэнгэл сум дахь Гал түймэр унтраах, аврах 39-р анги, Тэс сум дахь Гал түймэр унтраах, аврах 57-р анги, Улиастай сум дахь Гал түймэр унтраах, аврах 43-р анги, өвс тэжээлийн 5 цэг, Сонгино сум дахь шатахууны агуулах гэсэн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/218 дугаар тушаалаар Төрийн тусгай алба хаагч 129, энгийн 22, гэрээт ажилтан 5, нийт 156 орон тоотой ажиллаж байна.

Онцгой байдлын газрын хэмжээнд: Гал унтраах үндсэн албаны-4, гал унтраах туслах албаны -4, туулах чадвар бүхий Зил131-3, Газ66-1, шуурхай албаны Уаз пургон- 4, Газель-1, Ландкрузер 100-1, Уаз469-2, Туслах албаны Газ53-1, нийт 21 автомашин, 100 гаруй нэр төрлийн гал унтраах, аврах ажиллагааны багаж зэвсэглэмжтэйгээр үүрэг гүйцэтгэж байна.

2017 онд нийт 5,933.4 сая төгрөгийн хөрөнгөтэй ажилласнаас авлага 0.9 сая төгрөг, бараа материал 950.5 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 4,981.9 сая төгрөг байна.

2017 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 1,548.4 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 114.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэн холбогдох зардлуудад зарцуулсан байна.

5. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн аудитын журмыг ашигласан бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтан нартай ярилцлага хийж, асуулга, лавлагаа аван, санхүүгийн болон ажлын тайланг судлаж, нөхцөл байдлын шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллаа.

6. Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл

Аудитыг 2018 оны 07 сарын 16-наас 2018 оны 08 сарын 31-ний дотор гүйцэтгэх төлөвлөгөөтэй боловч цаг үеийн нөхцөл байдлаас болж 2018 оны 09 сарын 20-ны дотор хийж гүйцэтгэлээ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна шалгагдагч байгууллагын саналыг тусгасан болно.

7. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг дарга бөгөөд тэргүүлэх аудитор Л.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Г.Хашцэцэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Жалбаа, Г.Чулуунбаатар нар гүйцэтгэв.

8. Хүндрэл бэрхшээл

Аудитыг гүйцэтгэх явцад тус байгууллагын ахлах нягтлан бодогч нь эрүүл мэндийн шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгч Улаанбаатар хот руу эмчилгээнд явсан, бусад холбогдох албан тушаалтнууд ээлжийн амралтаа авсан нь аудитад шаардлагатай баримт бичиг гаргуулах, тайлбар тодруулга авах зэрэгт хугацаа алдаж аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

БҮЛЭГ 1. Ахлах нягтлан бодогч нь ажлын дадлага туршлагагүй, төсвийн шууд захирагчаас санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

1.1 Үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төлөвлөгөөнөөс 36,5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Тус байгууллага нь 2017 онд улсын төсвөөс авах санхүүжилтийг анх 1340,0 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2017 оны 05 сард тодотгол хийж 1538,1 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь Онцгой байдлын байгууллагуудын бүтцэд шинэчлэл хийж Улсын нөөцийн салбарыг онцгой байдлын газартай нэгтгэсэнтэй холбоотой байна.

Онцгой байдлын газар нь 2017 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 1501,6 сая төгрөг, төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын санхүүжилтээр 46,8 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 114,8 сая төгрөг, нийт 1663,2 сая төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг задлан үзвэл дараах байдалтай байна.
/сая.төг/

д/д	Зардлын төрөл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1339,8	1294,2	45,6
2	Ажил олгогчоос олгох НДШ	39,1	34,8	4,3
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,9	105,3	-12,4
4	Хангамж бараа материалын зардал	31,1	34,3	-3,2

5	Нормативт зардал	15,4	15,4	0
6	Эд хогшил, урсгал зардал	3,0	2,6	0,4
7	Томилолт	2,0	1,6	0,4
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	6,2	5,0	1,2
9	Бараа үйлчилгээний бусад зардал	6,1	6,2	-0,1
10	Бусад ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	2,5	2,2	0,3
ДҮН		1538,1	1501,6	36,5

Санхүүжилтийг дутуу төвлөрүүлсэн нь дараах хүчин зүйлстэй холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал хасагдсан нь төсвийн төслөө өгөхдөө албан хаагчдын цалин хөлсний нэмэгдлийг тооцож батлуулсан ч тухайн нэмэгдлүүдийг УИХ-ын 29 дүгээр тогтоолын дагуу хассан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох түлш халаалтын зардалд санхүүжилт нэмж олгосон нь тус байгууллагын шинэ байрыг ашиглалтанд оруулах явцад халаалтын зөрүү үүсэж, өр бий болсон
- Хангамж бараа материалын зардал болох тээвэр шатахууны зардалд санхүүжилт нэмж олгосон нь гал унтраах тусгай зориулалтын автомашин нэмэгдсэн зэрэгтэй тус тус холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг задлан үзвэл дараах байдалтай байна.

Орон нутгийн орлогоор:

- Аймгийн онцгой комиссын гишүүд өвөлжилт хүндэрсэн сумдаар явсан шатахуун, автомашины засварт зориулан 4,1 сая төгрөг
- Онцгой байдлын шуурхай хуралдааны бэлэн байдалд зориулан видео хурлын тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 8,0 сая төгрөг

ОБЕГ-ын санхүүжилтээр:

- Гэнэтийн аюул, ослын үед ажилласан алба хаагчдын томилолт, хоол унааны зардалд 24,3 сая төгрөг
- ЗГ-ын тогтоолын дагуу улсын нөөцөд хөнгөлөлттэй өвс тэжээл хүргэх тээвэр шатахууны зардалд 47,7 сая төгрөг
- НҮБ-ын тусламжийн багц хүргэх замын зардалд 4,5 сая төгрөг
- УНС-ын нөөцийн бараа материалын сэлгэлтийн зардалд 7,4 сая төгрөг
- Тэс сум дахь гал түймэр унтраах, аврах 57-р ангийн барилгын засварын зардалд 17,1 сая төгрөг
- ОБГ-ын автомашины бэлэн байдал хангах тос тосолгооны зардалд 1,2 сая төгрөг

Бусад эх үүсвэрээр

- Япон улсад төвтэй Хүүхдийг ивээх сангаас 0,35 сая төгрөгийн,
- Онцгой байдлын газрын шагналд 0,09 сая төгрөг, нийт 114,8 сая төгрөг байна.

1.2 Үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийг зориулалтын бус, бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан байна.

Тус байгууллага нь 2017 онд урсгал үйл ажиллагааны зардалд 1545,8 сая төгрөг зарцуулж, цалин хөлс нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг зардлуудын 2,6 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Урсгал үйл ажиллагааны зардлуудыг судлан үзэхэд дараах байдалтай байна.

/сая.төг/

Д/д	Зардлын төрөл	Санхүүжилт	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1294,2	1293,8	0,4
2	Ажил олгогчоос олгох НДШ	34,8	33,8	1,0
3	Гэрэл цахилгаан	9,8	6,1	3,7
4	Түлш халаалт	87,5	97,3	-9,8
5	Цэвэр бохир ус	8,0	1,9	6,1
6	Бичиг хэрэг	1,5	1,6	-0,1
7	Тээвэр шатахуун	30,7	29,8	0,9
8	Шуудан холбоо интернет	1,6	2,7	-1,1
9	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	0,5	0,2	0,3
10	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	0,8	0,8	
11	Хоол хүнс	13,8	13,8	
12	Нормын хувцас зөөлөн эдлэл	0,8	0,8	
13	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0,6	0,6	
14	Урсгал засвар	2,0	2,0	
15	томилолт	1,6	1,6	
16	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,0	5,0	
17	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,9	1,9	
18	Бараа үйлчилгээний бусад зардал	4,3	4,3	
19	Бусад ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	2,2	2,2	
20	Төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэмгэмж урамшуулал	46,8	45,6	1,2
ДҮН		1548,4	1545,8	2,6

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил:

2017 онд нийт 156 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар батлагдсанаас 152 орон тоотойгоор ажилласан байна.

Тус байгууллага нь 2017 онд албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшуулалд 1276,0 сая төгрөг , үр дүнгийн урамшуулал болон ээлжийн амралтаа биеэр эдлээгүй албан хаагчдад олгох урамшуулалд 15,8 сая төгрөг, ахмадын сан байгуулахад 2,0 сая төгрөгийг зарцуулсанаар тайлагнасан байна.

Гэтэл Онцгой байдлын газрын даргын 2017 оны Б/43 тоот тушаалаар ахмадын санг байгуулсан бөгөөд зарцуулалтыг судлан үзэхэд 0,8 сая төгрөгийг ахмадын үйл ажиллагаанд зарцуулж, 1,2 сая төгрөгийг засварын зардал болон автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авахад зарцуулсан байна.

Энэ нь тус байгууллагын урсгал засварын санхүүжилт хүрэлцдэггүй, мөн гэнэтийн онцгой нөхцөл үүсэхэд бэлэн байх шаардлагатай автомашинд засвар арчлалт зайлшгүй хийх болсонтой холбоотой гэсэн тайлбарыг өгч байна.

Эхийн чөлөөтэй албан хаагчид болон ажилчдын шилжилт хөдөлгөөн, байгууллагын орон тоо бүтэц шинэчлэгдсэн, орон тоо дутуу ажилласан зэрэгтэй холбоотой бий болсон цалингийн хэмнэлтийг үр дүнгийн урамшуулал болон ахмадын сан байгуулахад зарцуулжээ.

Аудитын явцад албан хаагчдын цалин тогтоолтыг МУ-ын ЗГ-ын 2007 оны 354, 2014 оны 332 дугаар тогтоолууд болон ОБЕГ-ын даргын 2017 оны А/86 тоот тушаалаар батлагдсан орон тоо, цалин тогтоолттой тулган үзэхэд алдаа зөрчил илрээгүй болно.

Хангамж, бараа материалын зардал:

Уг зардалд гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардлууд багтаж байгаа бөгөөд нийт 105,3 сая төгрөгийн зардал гарсан байна.

Үүнээс түлш халаалтын зардлыг судлан үзэхэд төсөвт 12,6 сая төгрөгийн тодотгол хийсэн хэдий ч төсвийг 9,8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэхүү хэтрэлтийг бүлэг дотор гүйлгэн зарцуулж, гэрэл цахилгаан болон цэвэр бохир усны хэмнэлтээс санхүүжүүлжээ.

Хэтрэлт үүссэн шалтгаан нь тухайн байгууллагын шинэ барилгыг ашиглалтанд орхоос өмнө халаалтанд холбогдсоноос үүссэн өр, шинэ байрны халаалтын зардлыг төлөвлөгөөнд тусгаагүй зэрэгтэй холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:

Уг зардалд бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл гэсэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах зардлууд багтах бөгөөд нийт 34,3 сая төгрөгийн зардал гарсан байна.

Үүнээс тээвэр шатахууны зардлыг судлан үзэхэд төсөвт 3,4 сая төгрөгийн тодотгол хийж, үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээр 30,7 сая төгрөг орж ирсэнээс 30,4 сая төгрөгийг, нэмэлт санхүүжилтээс 56,8 сая төгрөгийг, нийт 87,2 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд шилжүүлжээ.

Зарцуулалтыг харилцагч байгууллагаар авч үзэхэд:

- НИК ХХК-ны шатахууны дансанд 41,8 сая төгрөг
- НИК ХХК-ны талоны дансанд 24,9 сая төгрөг
- Магнай трейд ХХК-д 10,1 сая төгрөг
- Шунхлай петролиум ХХК-д 1,1 сая төгрөг
- Түдэвтэй сумын ЗДТГ-т 0,7 сая төгрөг
- Сонгино сумын ЗДТГ-т 1,0 сая төгрөг
- Их-Уул сумын ЗДТГ-т 0,8 сая төгрөг
- Тэлмэн сумын ЗДТГ-т 0,6 сая төгрөг
- ХЦ-ийн 0277 дугаар ангид 3,0 сая төгрөг
- Асгат сумын ЗДТГ-т 0,7 сая төгрөг
- Нөмрөг сумын ЗДТГ-т 2,5 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Үүнээс НИК ХХК-д шилжүүлсэн 66,7 сая төгрөгийн шатахуун болон талоны төлбөрийг судлан үзлээ.

- **Шатахууны тооцоо:** НИК ХХК нь 2017 онд шатахууны төлбөрт 46,1 сая

төгрөгийг тооцоо нийлсэн актаар нэхэмжилсэн байна. ОБГ нь уг төлбөрийн 0,6 сая төгрөгийг өмнөх оны авлагаар, 41,8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийн төсвөөс, 0,5 сая төгрөгийг НИК ХХК-ний урамшууллаар барагдуулсан бөгөөд 3,2 сая төгрөгийг ямар эх үүсвэрээс төлсөн нь тодорхойгүй байна.

- **Талоны тооцоо:** НИК ХХК-ний талоны дансруу шилжүүлсэн 24,9 төгрөгийн талоны зарцуулалтын тайлан, шаардах хуудсаар олгосон баримт ирүүлээгүй болно.

Зарцуулалтыг судлан үзэхэд:

- Үндсэн үйл ажиллагааны зардлаас талоны үнэнд шилжүүлсэн 1,35 сая төгрөгийг авто машины сэлбэг хэрэгсэл худалдан авахад зарцуулсан гэсэн тайлбарыг өгч байгаа хэдий ч холбогдох баримтаар нотлогдохгүй байна.
- Нэмэлт санхүүжилтийн зардлаас 23,55 сая төгрөгийг талоны үнэд шилжүүлсэн бөгөөд үүнийг дараах зардлуудад зарцуулсан байна.
 - Өвс тэжээл ачисан жолооч нарын тээврийн хөлсөнд 3,1 сая төгрөгийн талон өгсөн
 - Байгууллагын гадна тохижилтонд зориулан цемент худалдан авахад 2,5 сая төгрөг
 - Албаны автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авахад 2,0 сая төгрөг
 - ОБЕГ-ын дэргэдэх давтан сургалт сэргээн заслын төвд хэвтэн эмчлүүлэгчдийн эмнэлэгийн төлбөрт 1,5 сая төгрөг
 - Улиастай сум дахь гал унтраах, аврах 43-р ангийн гадна тохижилт, Тэс сум дахь 57-р ангийн 6 автомашины граж барих ажилд 14.45 сая төгрөг байна.

Зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Худалдан авсан шатахууны тайлагналт, зарцуулалтын талаар:

ОБГ нь Тосонцэнгэл сум онцгой байдлын хэлтэс болон гал унтраах 39-р анги, Тэс сум дахь гал унтраах 57-р анги, Улиастай сум дахь гал унтраах 43-р анги, УНС гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж нийт 21 ширхэг автотээврийн хэрэгсэл ашиглаж байна.

Дээрх анги салбаруудын шатахууны зарцуулалтаас Улиастай сум дахь гал унтраах 43-р ангийн шатахууны тайлантай танилцлаа.

Тус анги нь НИК ХХК-ний Улиастай сум дахь 3,4-р ШТС-аас шатлах тослох материалыг хамтран ажиллах гэрээг үндэслэн зээлээр худалдан авдаг байна.

2017 онд А-80 бензин 3505,64 летр, А-92 бензин 3465,7 летр, Дизель түлш 6650,67 летр, нийт 13622 летр шатах тослох материал худалдан авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Гэтэл ОБГ-ын шатахууны тайланд А-80 бензин 3239,1 л, А-92 бензин 535 л, дизель түлш 5207,1 л, нийт 8981,2 л шатах тослох материал тусгагдсан байна.

Шатлах тослох материалын тайлан зөрүүтэй тусгагдсантай холбоотой 8,3 сая төгрөгийн алдаа илэрсэн бөгөөд энэ нь нэмэлт санхүүжилтийн хөрөнгөөр худалдан авсан шатахууны тайланг гаргалгүй орхигдуулсантай холбоотой байна гэж үзлээ.

Аудитын явцад шатахууны тайланг гаргахдаа нэхэмжилсэн дүнгээр биш шилжүүлгийн дүнд тохируулан гаргадаг, нэхэмжлэлд тусгагдсан шатлах тослох материалын нэр төрөл зөрүүтэй тусгагдсан, дараа сарын тайланг гаргахдаа өмнөх сарын үлдэгдлийг нэмж тайлагнадаггүй зэрэг алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Нормативт зардал:

Уг зардалд эм бэлдмэл, хоол хүнс, нормын хувцас зөөлөн эдлэл зэрэг зардлууд багтаж байна.

Хоол хүнсний зардалд 13,8 сая төгрөг зарцуулсан бөгөөд зарцуулалтыг судлан үзэхэд ХААН банкны түр дансруу албан хаагчдад олгох хоолны мөнгийг шилжүүлж жагсаалтаар олгодог байна. Гэтэл зарим сард хоолны мөнгийг дутуу олгосон, хоолны зардлыг бусад бараа материалын зардалд зарцуулсан зэрэгтэй холбоотой 0.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Хоол хүнсний зардлыг ээлжийн ажилтай албан хаагчдад олгодог байна.

Нэг удаагийн тэтгэмж урамшуулал:

Албан хаагчдад эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд нь байгууллагаас дэмжлэг үзүүлэхэд 2,2 сая төгрөг, Төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 45,6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Зарцуулалтын судлан үзэхэд:

-Өндөр настнуудыг сувилалд хэвтэн эмчлүүлэх зардалд 0.5 сая төгрөгийг олгох тушаал гаргасан хэдий ч уг мөнгийг гал унтраах олон төрөлт тэмцээнд оролцогчдын хоолонд зарцуулсан

-ОБЕГ-ын давтан сургалт сэргээн заслын төвд хэвтэн эмчлүүлэгчдийн /10/ эмчилгээний зардал 2,1 сая төгрөгийн 1,5 сая төгрөгийг талоноор төлсөн бөгөөд зөрүү 0,6 сая төгрөгийг шийдвэргүйгээр үйл ажиллагааны санхүүжилтээс олгосон,

Дээр дурьдсанаас бусад зардлуудыг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэлгүй ажилласан байна.

Мөн үндсэн үйл ажиллагааны зарцуулалтыг үзэх явцад сэлбэг хэрэгсэл, шуудан холбоо, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлууд хүрэлцээ муутай байгаа нь ажиглагдлаа.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 39,5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага, зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.3 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг холбогдох зардлуудад зарцуулжээ .

Нэмэлт санхүүжилтээс 114,2 сая төгрөгийн зардал гарч, 0,6 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг судлан үзэхэд дараах зөрчил илэрлээ.

- ОБЕГ-аас аймаг бүрийг видео хурлын тоног төхөөрөмжтэй болох талаар албан тоот ирүүлсэн байна. Уг тоотын дагуу Аймгийн засаг даргад хүсэлт гарган 8,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэнээс 4.0 сая төгрөгийг видео хурлын тоног төхөөрөмж, 3,9 сая төгрөгийг өвс тэжээл тээвэрлэх зориулалтын авточиргүүл, цаг хүндэрч зам даваа хаагдсан нөхцөлд ашиглах зориулалттай далпуу /зам гаргах, малын бэлчээр гаргах/ худалдан авахад
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн онцгой байдлын болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын томилолт болох 24,3 сая төгрөгийн санхүүжилтээс 2,3 сая төгрөгийг тээвэр шатахууны зардал руу зориулалт бусаар гүйлгэн зарцуулсан,

Нэмэлт санхүүжилтээс НИК ХХК руу шилжүүлсэн шатахууны зарцуулалтын талаар тайлангийн 1.2 дахь хэсгийн хангамж бараа материалын хэсэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

1.4 Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажлаагүй байна.

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар нийт 65,1 анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг шалган үзэхэд анхан шатны баримтын бүрдүүлэлт сайжраагүй байна.

Тухайлбал: Сумдад болон шатахуун түгээх станц руу шилжүүлсэн тээвэр шатахууны зарцуулалтын баримтын бүрдэл дутуу, зарим баримт нь тухайн ажил гүйлгээтэй уялдахгүй зэрэг зөрчил арилаагүй байна.

Аудитаар анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, зарим баримт огт байхгүй байдал ажиглагдлаа. Тухайлбал:

- Ажилчдын цалин хөлс бодолтыг шалгаж үзэхэд ажилчдын зарим сарын цагийн тооцооны бүртгэл байхгүй, цагийн тооцооны товчоо гаргахдаа цагийн бүртгэлд үндэслэн гаргаагүй, санхүүгийн баримтанд үдэгдээгүй,
- Бүх анги салбаруудын худалдан авсан шатахууны нэхэмжлэлийг шатах тослох материалын нэр төрлөөр бичүүлж аваагүй бөөн дүнгээр бичигдсэн, зарцуулалтын тайлангийн зарим сарын тайлан, замын хуудас, тооцоо бодсон баримт байхгүй, аудитын явцад зарим баримтыг бүрдүүлж өгсөн,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага буюу сургалт сурталчилгаа явуулахад зарцуулсан хөрөнгийн баримтыг бүрдүүлэхдээ зөвхөн холбогдох газрын шийдвэр болон төсвийг хавсаргасан, бусад анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу
- Талоны зарцуулалтыг үзэхэд талоны тайлан, шаардах хуудсаар олгосон баримт байхгүй зэрэг алдаа зөрчлүүд байна.

Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь ахлах нягтлан бодогч болон бусад санхүүгийн ажилчдын туршлага, ажилдаа хандах хандлага, ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7. /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно/ гэсэн заалтыг зөрчиж байна.

Эдгээр алдаа зөрчлийг арилгуулах, цаашид засаж залруулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.5 Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Тус байгууллагын санхүү, аж ахуйн алба нь ахлах нягтлан бодогч, туслах нягтлан бодогч, кассын нярав, Тосонцэнгэл, Тэс, Улиастай суманд байрлах гал түймэр унтраах ангиудад тус бүр 1 нярав, улсын нөөцийн нярав гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2017 оны үйл ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газраас дотоод аудитын шалгалт хийгдсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна. Мөн Бусад хяналт шалгалтын байгууллагаас 2017 оны үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллагад дотоод хяналт хариуцсан нэгж ажилдаг хэдий ч тухайн ажилтаны ажил үүргийн хуваарьт санхүүгийн үйл ажиллагаа руу чиглэсэн заалт тусгагдаагүй байна.

Онцгой байдлын газрын даргын тушаалаар НИК ХХК-ний шатахууны өр авлагыг нягтлан шалгах комисс, Улиастай, Тэс сумдад баригдаж байгаа барилгын гадна болон дотор талын тохижилтонд зориулж авсан барилгын бараа материал болон эд аж ахуй, машин техник, багаж хэрэгсэлд санхүүгийн хяналт шалгалт явуулах комиссыг тус тус байгуулан ажилласан ч шалгалт хийсэн ажлын дүнг удирдлагад танилцуулаагүй, алдаа зөрчлийн талаар ажил зохион байгуулж ажлаагүй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах эрх бүхий албан тушаалтангууд нь гаргасан аливаа шийдвэрийнхээ хэрэгжилтэнд хяналт тавьдаггүй, санхүүгийн үйл ажиллагаа нь урсгалаар явагдаж байна.

Энэ нь ахлах нягтлан бодогчийг томилохдоо сонгон шалгаруулалт явуулаагүй, Төсвийн тухай хууль болон ажлын байрны тодорхойлолтонд тусгасан шаардлагыг харгалзан үзээгүйгээс ажлын тушлага дутагдаж байгаа нь ажиглагдлаа.

БҮЛЭГ 2. Хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд тавих хяналт хангалтгүй байна.

2.1 Одоо ашиглаж байгаа хөрөнгө нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна.

Тус байгууллага нь 2017 онд 6729,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 950,5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2017 онд тус байгууллагын үндсэн хөрөнгө 4067,6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь гал унтраах аврах 43-р ангийн галын депогийн барилга, Тэс сум дахь гал унтраах аврах 57-р ангийн ажлын байр шинээр ашиглалтанд орсон, Улсын нөөцийн салбарыг онцгой байдлын газартай нэгтгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Онцгой байдлын газар нь 2 дугаар зэрэглэлийн Гал түймэр унтраах, Аврах 43-р анги, 3 дугаар зэрэглэлийн Тосонцэнгэл сумын Гал түймэр унтраах, Аврах 39-р анги, 4 дүгээр зэрэглэлийн Тэс сум дахь Гал түймэр унтраах, аврах 57-р ангиудад Гал унтраах үндсэн болон туслах албаны автомашин болон багаж зэвсэглэмжийн хангалт 80 хувьтай байгаа бөгөөд “Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6412:2013 стандартад заагдсан гал унтраах тусгай зориулалтын авто өргөгч, гэрэл холбооны, ой хээрийн түймэр унтраах хөөс нунтаг, гал унтраах автомашин аврах ажиллагааны тусгай зориулалтын автомашин, механизмаар хангагдаагүй гэсэн тайлбарыг өглөө.

Онцгой байдлын газрын машин тоног төхөөрөмж, багаж зэвсэглэмжийн тоо хэмжээ нь нууцын зэрэглэлтэй тул аудитын явцад үзэх боломжгүй байлаа.

2.2 Хандив тусламж болон хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Үндсэн хөрөнгийн тооллогыг оны эцэст хийж тооцоо бодон ажилласан байна.

Аудитын явцад 2017 онд хөрөнгө оруулалт болон өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэсэн ажлын үр дүн, худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, хандив тусламжаар нийлүүлэгдсэн хөрөнгийн ашиглалтын байдалтай бодит байдал дээр нь очиж танилцан, баримтжуулалт хийлээ.

Шинэ барилга ашиглалтанд орсонтой холбоотой хандив тусламж, хөрөнгө оруулалт, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бий болгосон хөрөнгүүдийг данс бүртгэлд тусган ажлаагүй байгаад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Тус хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгахдаа өмч хамгаалах комиссоор хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрийг үндэслэн бүртгэлжүүлэх нь зүйтэй байна.


ДҮГНЭЛТ:

Онцгой байдлын газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

- Төсвийн хөрөнгийг зориулалт бус, бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан зөрчил гаргасан ч тухайн байгууллагын өнгө үзэмж, албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан байна.
- Ахмад настангуудад дэмжлэг үзүүлж байгаа нь сайшаалтай хэдий ч тухайн зардлыг төсөвт тусгалгүй зарцуулж байгаа нь эрсдэлтэй байна.
- 2017 оны касс, бараа материалын тайлан архивлагдаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт, хадгалалт, архивын баримтын эмх цэгц хангалтгүй байна.
- Санхүүгийн ажилчдыг сонгон шалгаруулахдаа Төсвийн тухай хууль болон ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

Онцгой байдлын газраас ирүүлсэн саналыг шийдвэрлэсэн байдал:

Онцгой байдлын газрын даргын 2018 оны 09 сарын 14-ны өдрийн 27/299 тоот албан бичгээр аудитын тайлан болон зөрчил төлбөртэй холбоотой дараах санал хүсэлт ирүүлсэн байна.


**ЗАВХАН АЙМАГ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР**
81000, Богдын гол баг, Улиастай сум, Завхан аймаг
Утас/Факс: 7046-2639
E-mail: zavkhanontsogi@yahoo.com

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Л.УЛАМБАЯР ТАНАА

2018.09.14 № 27/299
тантай _____-ны № _____ т

Хүсэлт гаргах нь

Манай байгууллагын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэлийн аудит хийж тайлангийн төслийг хүргүүлснийг хүлээн авлаа.

Аудитын урьдчилсан дүгнэлтээр 50,9 /тавин сая есөн зуун мянга/ төгрөгийн зөрчил, 5,9 /таван сая есөн зуун мянга/ төгрөгийн актын төлбөр гарсанд дараах тайлбарыг өгч байна.

Үүнд:

1. Улиастай сумд баригдсан Галын депогийн 55x24 харьцаатай, 3 давхар барилга нь 2014 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхэлж, 2017 онд гүйцэтгэгч байгууллага нь хуваарийн дагуу санхүүжилтээ авч чадаагүйн улмаас өр авлагад орсон гэдэг шалтгаанаар барилгын гадна болон дотор талын засвар тохижилтын ажлыг дутуу хаясныг гүйцээн ашиглалтад оруулсан.
2. Тэс сумд шинээр байгуулагдсан Гал түймэр унтраах, аврах 57 дугаар анги нь гал унтраах албаны 2, Аврах ажиллагааны Пургон, Зил 131, Фотон трактор зэрэг машин техниктэйгээр байгуулагдаж, эдгээр авто машинуудыг байрлуулах гражийг зайлшгүй барих шаардлагатай болж 6 авто машины гражийг барьж ашиглалтад оруулсан.
3. Тосонцэнгэл сумд Онцгой байдлын хэлтсийн байранд урсгал засвар хийсэн зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг хамт олны хүч, байгууллагын дотоод нөөц боломжоо ашиглан хийсэн.
Дээрх бүтээн байгуулалт, засварын ажлыг хийж гүйцэтгэхэд нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн тээврийн хөлс, шатахууны санхүүжилтийг барилгын материал авахад болон тээврийн хөлсөнд зарцуулсан.
4. Мөн 2017 онд ойрын жилүүдэд болж байгаагүй хэт халалт болж хуурайшилтын нэн аюултай зэрэглэлд хүрч ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, пост ажиллуулах, ард иргэдэд ухуулга, сурталчилгаа

D:2018:ALBAN BICHIG L42018

2

хийх түймэр гарсан үед унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, бэлэн байдлыг хангах зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг аймаг сумын хэмжээнд өргөн хүрээнд авсны үр дүнд ой, хээрийн томоохон түймэр гараагүй.

Улсын хэмжээнд тархаж байгаа малын гоц халдварт шүлхий, мялзан өвчний 4 голомт илэрснийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран 1-2 сарын хугацаанд хорио цээрийн дэглэмийг тогтоож, харуул хамгаалалт гаргаж, ариутгал халдваргүйжүүлэлтийг сайтар хийж, ард иргэд, малчдад ухуулга, сурталчилгаа, сургалтуудыг олон удаа хийсний үр дүнд Завхан аймаг өнөөдөр малын гоц халдварт өвчингүй цөөхөн аймгийн тоонд багтаж, аймгийн эдийн засагт учирч болзошгүй томоохон хохирлыг бууруулсан.

Сантмаргац сумын Баяннуурт Оросын холбооны улсын иргэн осолдож 7 хоног эрлийн ажиллагааг өргөн хүрээнд, шуурхай зохион байгуулан цогцсыг нь олж Оросын холбооны улсад хүлээлгэн өгсөн.

Отгонтэнгэр хайрханд 17 уулчны амь нас эрсдэж далайн төвшнөөс дээш 3500 метр өндөрт олон хүн, машин техник ажилласан зэрэг томоохон гамшиг ослууд ойр ойрхон гарч ихээхэн хэмжээний төлөвлөгдөөгүй зардлууд гарч өр авлага үүсч санхүүгийн анхан шатны баримт материалыг бүрдүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байсан.

5. Байгууллагын жилийн төсөв нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад хүрэлцэхгүй, одоо мөрдөгдөж байгаа үнэ тариф болон зах зээлийн үнэ ханшнаас хэд дахин бага, мөн онд дээр дурдсан Улиастай сумд Гал унтраах дөнгөийн 3 давхар байр, Тэс сумд конторын байр, 6 автомашины граж нэмэгдэж ашиглалтад орсонтой холбогдон тогтмол зардлууд болон үйл ажиллагааны зардлууд нэмэгдэж тухайн онд төсвийн тодотгол хийгдээгүйн улмаас өр авлага үүсч, зардал хооронд зайлшгүй шилжүүлэн зарцуулах шаардлага гарсан зэрэг хүчин зүйлүүдээс гадна Улсын нөөцийн салбар нь хөрөнгө, санхүүгийн хувьд нэгдэж өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах болсон, нягтлангуудын ажлын уялдаа холбоо, дадлага туршлага муутай байсан зэрэг нь дээрх зөрчил гарахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Зөрчлийн мөрөөр Онцгой байдлын Ерөнхий газрын даргын тушаалаар ОБГазрын дарга миний бие цалингийн 2 сар 20 хувиар шийтгүүлж арга хэмжээ авахуулсан.

Ахлах нягтлан бодогч дэслэгч Ц.Сүхбатыг Онцгой байдлын газрын даргын зөвлөлийн хурлаар ажлын байрыг өөрчлөхөөр ОБЕГ-т саналыг хүргүүлсэн зэрэг арга хэмжээ авснаас гадна цаашид дахин санхүүгийн зөрчил гаргахгүйн тулд

3

Онцгой байдлын газрын нягтлан бодогч, нярав нарт гүйцэтгэлийн аудитаар өгсөн заавар, зөвлөмжийг удирдлага болгон ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргуулан тусгайлан үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Гүйцэтгэлийн аудитаар анхан шатны баримт материалын бүрдүүлэлт дутуу гэх үндэслэлээр 5963800 /таван сая, есөн зуун жаран гурван мянга, найман зуу/ төгрөгийн зөрчлийг дурдсан актад дараах тайлбарыг өгч байна.

Үүнд:

Төлбөр 1. Хоолны зардлаас нярав Н.Бат-Амгалангийн дансруу шилжүүлсэн 1,163,800 төгрөгийн баримт нь байгаа бөгөөд зарцуулалт нь Марш-тактикийн тэмцээнд оролцох алба хаагчдыг байрлаж байх хугацаанд хоолны материал авч 14 хоног хооллож байсан.


Төлбөр 2. Мөн НИК ХХК-ийн талоны дансруу шилжүүлсэн 4,800,000 төгрөг нь Тэс сумын Гал түймэр унтраах, аврах 57 дугаар ангийн авто машины гражийг хүйтрэхээс өмнө барьж дуусгах зорилгоор мод зүсвэрийн хөлс болох 1530000 төгрөг, мөн тус газрын алба хаагчдын хүүхдийг, хүүхдийн баяраар 1,140,000 төгрөгийн бэлэг тараасан бөгөөд үлдэгдэл 1,860,000 төгрөгөөр шинээр ашиглалтад орсон конторын байранд алба хаагчдын сандал ширээ бусад тавилга шинээр авч тавьсан байна.

Иймд дээрх анхан шатны баримт материалуудыг үндэслэн төлбөрийг хүчингүй болгож өгөхийг хичээнгүйлэн хүсье.

Манай байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон хамт олны хийж бүтээн байгуулсан ажлуудтай биечлэн танилцаж үнэлгээ дүгнэлт өгч, зөрчил дутагдалд заавар зөвлөмж өгсөн танай байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Цаашид санхүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, та бүгдийн өгсөн заавар зөвлөмжийг удирдлага болгон санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллахаа илэрхийлье.

ДАРГА
ХУРАНДАА



Ө.БОЛД

Дээрх саналд 2017 онд хийсэн бүтээн байгуулалтын ажлын талаар тайлбар ирүүлсэн бөгөөд төлбөрийн актын 5,9 сая төгрөгийг чөлөөлүүлэх хүсэлт ирүүлсэнг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах арга хэмжээг авсан болно.

1. Хоолны зардлаас нярвын дансанд шилжүүлсэн 1,2 сая төгрөг нь анхан шатны баримтын бүрдэлгүй байсан бөгөөд аудитын явцад кассын нярав нь ар гэрийн гачигдлын улмаас Улаанбаатар хот руу явсан тул тодруулах боломжгүй байсан учир төлбөрийн актыг төслөөр хүргүүлсэн. Аудитын тайланд санал авах явцад тус албан хаагч ирж холбогдох материалыг үзүүлсэн бөгөөд уг баримтыг хангалттай нотолгоо байна гэж үзэн удирдлагын зөвлөлийн хурлаас зөрчил, төлбөрийн актаас чөлөөлөх шийдвэр гаргасан болно.
2. НИК ХХК-аас худалдан авсан 4,8 сая төгрөгийн талоны зарцуулалтын тайлан байхгүй байсанд төлбөрийн актыг төслөөр оруулсан. Гэтэл талоныг зориулалт бус зарцуулсан баримт ирүүлсэн бөгөөд уг асуудлыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж зориулалт бус зарцуулсан хэдий ч ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг бэхжүүлэх ажилд зориулсан учир төлбөрийн акт тогтооход төлөгдөх боломжгүй байна гэж үзэж төлбөрийн актаас чөлөөлж, зөрчлөөр тооцох шийдвэр гаргасан болно.

ДАРГА, БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ө.Болд-д

Үндэсний аудитын газрын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн Онцгой байдлын газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж ажиллах
2. Дотоод аудитын нэгжийн ажил үүргийн хуваарьт санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих талаар тусгаж, арга зүйгээр хангаж ажиллах
3. Шатах тослох материалын тайланг үнэн зөв гаргаж жолоочийн замын хуудсыг тухай бүр хөтлөж, тооцоо бодож байх.
4. Санхүүгийн ажилчдын ажлын уялдааг сайжруулж, анхан шатны баримтын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2018 оны 11 сарын 15-ны дотор албан тоотоор ирүүлэх .

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л. УЛАМБАЯР